



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Сайд нарын Зөвлөлийн
Т О Г Т О О Л

1958 оны 8 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 276

Улаанбаатар
хот

Улаанбаатар хотын пионерийн
ордонг ажиллагаанд оруулах
тухай.

Б.Н.М.А.Улсын Сайд нарын Зөвлөлөөс **Т О Г Т О О Х** нь:

1. Сургуулийн хичээлийн жилийн нээлтийг тохиолдуулан,
улаанбаатар хотын пионерийн ордонг 1958 оны 9 дүгээр сарын
15-ны наана амжилтаанд нь оруулсугай.

2. Улаанбаатар хотын пионерийн ордонг Гэгээрлийн Яамны
шууд харьяанд ажиллуулсугай.

3. Пионерийн ордонд Гэгээрлийн Яамны хувиарын ёсоор
хүүхдэд зориулан ажлаагоор тогтмол үйлчилж байхыг Соёлын Яам
/н.СОСОРБАРАМ/-д үүрэг болгосугай.

4. Пионерийн ордонд авто засварын базаас ачааны хуучин
авто машин 1, мөн өсжих газраас нь усны цистерн 1-ийг шилжүүлэн
өхийг Улсын Төлөвлөгөөний Комисс/н.ДУЛМАА/-д даалгасугай.

5. Техникийн дугуйлангийн хэрэгцээнд зориулан, хуучин
мотоцикл 2-ийг пионерийн ордонд үнэгүйгээр шилжүүлэн өхийг
ардын цэрэгт туслах сайн дурын нийгэмлэг/н.ЛХАГВАСҮРЭН/-д
даалгасугай.

6. Пионерийн ордон бүх кабинет, лабораторийг төхөөр-
өмжлөн ажиллуулж тавиар Гэгээрлийн Яаманд мэрэгжлийн тус-
лалцаа үзүүлдэг ажилтнуудтай зайлаштгүй шаардагдах зүйлийг гарган
өхийг дор тусгай тусгай газруудад үүрэг болгосугай;

7. Улаанбаатар хотын цэвэрлэх байгуулахад Хөдөө Аж
Ахуйн Яамнаас трактор, хөдөө аж ахуйн машиныг

үнэгүйгээр шилгүүж, мэрэгжлийн туслалцаа үзүүлсүгэй;

б/ биеийн тамир, спортын павильон байгуулахад Улсын биеийн тамир, спортын хэрэг эрхлэх хөрсөнөөс мэрэгжлийн туслалцаа үзүүж, спортын төхөөрөмж хөрөгслийг өөрийн захиалгат зүйлээс гарган өгсүгэй;

в/ цэцэрлэг, ногооны теплиц байгуулахад Улаанбаатар хотын гүйцэтгэх захиралнаас зохих туслалцаа үзүүлсүгэй;

г/ радио уяал, лабораторийн монтажийн ажлыг Тээвэр, Холбооны Яамнаас хийж өгсүгэй;

д/ цаг уурын станцыг Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэнгээс байгуулж өгсүгэй.

Б.Н.М.А.Улсын Сайд
нарын Зөвлөлийн
орлогч дарга

МОЛОМЖАМЦ

Б.Н.М.А.Улсын Сайд
нарын Зөвлөлийн Хэрэг
Эрхлэх Газрын I - р
орлогч дарга

ЦЭРЭНХАВ

Хуулбар үнэн: Тогтоол ангийн
эрхлэгч

ЛАГВАДОРЖ

